



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/630

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Наран багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Хан-Алтай ресурс" ХХК-ийн нуруулдан уусгах 4-6 дугаар үүрийн байгууламжийн ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)

Гишүүдэд: М.Мандаххүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)  
П.Аззаяа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)  
Б.Батбилэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн улсын байцаагч)  
М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн байгууламж хариуцсан мэргэжилтэн)  
Б.Энхцацрал ("Хан-Алтай ресурс" ХХК-ийн төслийн удирдагч)  
Б.Мягмаржав ("Хан-Алтай ресурс" ХХК-ийн төслийн ахлах мэргэжилтэн)  
Б.Сүхбаатар ("Силвер Эделвэйз" ХХК-ийн захирал) (зохиогч)

Нарийн бичгийн дарга: А.Гэрэлтуяа ("Хан-Алтай ресурс" ХХК-ийн төслийн зөвшөөрлийн зохицуулагч)

2.Байгууламжийн улсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

